



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

┌ Хорооны 2014 оны 7 дугаар тогтоолоор ┐
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам”-ын 4 дүгээр зүйлд доор дурьдсан агуулгатай дараах 4.8, 4.9, 4.10 дахь хэсгүүдийг тус тус нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.8, 4.9, 4.10 дахь хэсгүүд:

“4.8. Зохицуулалттай этгээд нь Хорооны даргын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр номинал дансаар дамжуулан харилцагчдад брокерийн үйлчилгээг үзүүлж болно.

4.9. Зохицуулалттай этгээд нь номинал данс эзэмших зөвшөөрөл авахдаа дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

4.9.1. 400 сая төгрөгөөс доошгүй хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;

4.9.2. үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн бэк оффисийн /back office/ програмтай байх ба тус програм нь арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагын системд нийцсэн, тэдгээрийн шаардлагыг хангасан байх;

4.9.3. үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн чиглэлээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх бүхий номинал данс хариуцсан мэргэжилтэнтэй байх бөгөөд тэрээр тусгай зөвшөөрөл бүхий компанийн гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнээр хавсран ажилладаггүй байх;

4.9.4. харилцагчийн мөнгөн хөрөнгийн бүртгэл, арилжааны мэдээллийг сар бүр тогтмол Хороонд ирүүлж байх.

4.10. Энэхүү журмын 4.9-д заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол Хорооны дарга тухайн брокерийн компанид номинал данс эзэмших зөвшөөрөл олгохоос татгалзана”.

2. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000162